

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга	
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ, АХМАД Х.БАТБАЯР
ТАНАА

2020.02.07 № 06/635
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал, ахмад Х.Батбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, элэгдэл дууссан ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Б.Буяндэлгэр, туслах аудитор Э.Номинчулуун нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 8 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд

аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хоригдлыг хоригдож байгаа хугацаанд болон суллагдсаны дараах нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд” оршино.

Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 159 дүгээр тогтоолоор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/169 дүгээр тушаалаар Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжлийн боловсрол олгох;
- Эзэмшсэн мэргэжлээрээ ажлын байраар хангагдах;
- Гэмт хэргийн улмаас иргэн хуулийн этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, боломжийг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн ур чадвартай ажилтан бэлтгэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Нью Радианс” ХХК-ийн “Юникус” программ хангамж ашигладаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 408,324.1 мянган төгрөгөөс тооцон 4,083.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түшинг 4,192.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,901.7 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	50.0	50.0
Бараа материал	38,646.3	38,971.6	325.3
Үндсэн хөрөнгө	61,213.3	45,936.3	(15,277.0)
Нийт хөрөнгө	99,859.6	84,957.9	(14,901.7)
Өр төлбөр		50.0	50.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	99,859.6	84,957.9	(14,901.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	99,859.6	84,957.9	(14,901.7)

Бараа материалын данс худалдан авсан хичээл үйлдвэрлэлийн хэрэглэлийн дүнгээр өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс худалдан авсан 7,621.0 мянга, шилжүүлэн авсан 418.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн. Хасагдсан хөрөнгө байхгүй байна. Бараа материалын зардал нэмэгдсэн нь хичээл үйлдвэрлэлийн материал авсан байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант үеийн элэгдэл, хорогдлын зардлаас шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хөтөлбөрт зориулан 403,249.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 403,249.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардал 403,249.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 401,389.0 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 1,860.2 мянган төгрөгийн хэмнэлт гарснаас шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 27,175.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,267.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,111.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 22,796.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч байна. Үүнээс:

1. Шатахууныг норм лимитээр тооцож олгоогүйгээс 3,111.1 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан нь “үнэн зөв байх” батламж мэдэгдэл, Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаалын 1 дүгээр хавсралт, Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2. Цалин, ээлжийн амралтын олговрыг 1,267.3 мянган төгрөгөөр давхардуулж олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулга хийлгэсэн.

Аудитаар илэрсэн 22,796.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 143 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй болно.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22,796.7 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “ Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл: Үндсэн хөрөнгө бодит үнэ цэнээрээ үнэлэгдээгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох стандарт, зааврын дагуу үнэлж, ашиглагдах жил, үнийг шинэчлэн тогтоох.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 22 тоот албан бичгээр алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>38,646,295.77</u>	<u>39,021,655.77</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	50,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	50,000.00
3121	Төгрөг	-	50,000.00
31211	Төрийн сангийн харилцах	-	50,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	38,646,295.77	38,971,655.77
351	Түүхий эд материал	1,648,000.00	1,648,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,648,000.00	1,648,000.00
354	Хангамжийн материал	36,998,295.77	37,323,655.77
35410	Бичиг хэргийн материал	793,110.00	654,920.00
35420	Аж ахуйн материал	23,493,866.00	23,569,914.00
35440	Түлш, шатах тослох материал	1,209,900.00	34,000.00
35450	Барилгын засварын материал	2,737,219.77	4,067,921.77
35470	Бусад хангамжийн материал	8,764,200.00	8,996,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,213,296.24</u>	<u>45,936,287.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	61,213,296.24	45,936,287.91
392	Биет хөрөнгө	59,133,091.19	44,743,621.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,000,000.00	43,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,400,000.00)	(40,525,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,216,880.60	65,799,817.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,629,498.72)	(40,812,316.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,080,883.00	35,536,946.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,135,173.69)	(18,255,825.93)
393	Биет бус хөрөнгө	2,080,205.05	1,192,666.57
39301	Програм хангамж	4,437,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,357,487.26)	(3,245,025.74)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>99,859,592.01</u>	<u>84,957,943.68</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>50,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	50,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>99,859,592.01</u>	<u>84,907,943.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	99,859,592.01	84,907,943.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,997,652.44	38,997,652.44
51101	Өмч: - төрийн	38,997,652.44	38,997,652.44
512	Хуримтлагдсан үр дүн	60,861,939.57	45,910,291.24
51210	Өмнөх үеийн үр дүн	60,861,939.57	60,861,939.57
51220	Тайлант үеийн үр дүн	-	(14,951,648.33)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>99,859,592.01</u>	<u>84,957,943.68</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	427,840,298.53	404,337,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	882,682.93	1,088,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	882,682.93	1,088,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	93,703.16	1,088,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	788,979.77	1,088,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,957,615.60	403,249,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	417,609,400.00	403,249,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	417,609,400.00	403,249,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	402,358,342.89	419,289,548.33
	Хөрөнгийн	9,348,215.60	0.00
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	408,324,142.89	419,289,548.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	408,324,142.89	419,289,548.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,989,106.99	416,429,341.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,590,574.21	296,683,620.43
210101	Үндсэн цалин	174,925,271.23	192,577,220.43
210102	Нэмэгдэл	97,665,302.98	102,106,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	1,000,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,767,093.05	5,852,072.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,767,093.05	5,852,072.47
2104	Хангамж, бараа материалын зардал	27,315,324.00	24,573,200.00
210401	Бичиг хэрэг	1,501,880.00	1,240,150.00
210402	Тээвэр, шатахуун	19,150,000.00	19,062,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	970,600.00	595,000.00
210408	Бараа материал акталсны зардал	3,692,844.00	2,375,950.00
2105	Нормативд зардал	5,752,000.00	0.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	712,000.00	0.00
210502	Хоол, хүнс	5,040,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,250,000.00	5,471,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,000.00
210604	Урсгал засвар	15,250,000.00	5,470,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,927,500.00	17,194,000.00
210702	Дотоод албан томилолт	13,927,500.00	17,194,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,782,100.00	7,442,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,660,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	213,800.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,100.00	277,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,390,715.73	59,213,348.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,260,060.00	35,897,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,130,655.73	23,316,008.33

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,335,035.90	2,860,207.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,335,035.90	1,860,207.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,335,035.90	1,860,207.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	19,516,155.64	(14,951,648.33)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	19,516,155.64	(14,951,648.33)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	417,699,400.00	403,299,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,000.00	50,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	90,000.00	50,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,000.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	0
120009	Бусад орлого	0	50,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	417,609,400.00	403,249,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	417,609,400.00	403,249,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	417,609,400.00	403,249,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,781,530.00	395,628,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,781,530.00	395,628,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,446,494.10	392,767,992.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,586,871.05	296,683,620.43
210101	Үндсэн цалин	174,921,568.07	192,577,220.43
210102	Нэмэгдэл	97,665,302.98	102,106,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	1,000,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,767,093.05	5,852,072.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,767,093.05	5,852,072.47
2104	Хангамж, бараа материалын зардал	22,585,000.00	19,827,200.00
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	560,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,985,000.00	17,372,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	595,000.00
2105	Нормативт зардал	5,752,000.00	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	712,000.00	0
210502	Хоол, хүнс	5,040,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,172,130.00	7,449,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,422,130.00	1,379,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	600,000.00
210604	Урсгал засвар	15,250,000.00	5,470,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,927,500.00	17,194,000.00
210702	Дотоод албан томилолт	13,927,500.00	17,194,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,995,900.00	7,442,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	3,660,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	213,800.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,100.00	277,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,660,000.00	38,320,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	320,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,360,000.00	38,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,335,035.90	2,860,207.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,335,035.90	1,860,207.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,335,035.90	1,860,207.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	14,917,870.00	7,671,000.00

	ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	14,917,870.00	7,621,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,917,870.00	7,621,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,917,870.00	7,621,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,917,870.00	7,621,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-14,917,870.00	-7,621,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	50,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	50,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44	00.00	41,245,783.93	80,343,436.37
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,997,652.44	00.00	41,245,783.93	80,343,436.37
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	19,516,155.64	19,516,155.64
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44	00.00	60,861,939.57	99,859,592.01
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44	00.00	60,861,939.57	99,859,592.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,997,652.44	00.00	60,861,939.57	99,859,592.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,951,648.33	-14,951,648.33
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44	00.00	45,910,291.24	84,907,943.68

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэлийн		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	403,249,200.00	401,388,992.90	1,860,207.10	99.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403,249,200.00	401,388,992.90	1,860,207.10	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,249,200.00	400,388,992.90	1,860,207.10	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,234,100.00	296,683,620.43	1,550,479.57	99.4
210101	Үндсэн цалин	194,127,700.00	192,577,220.43	1,550,479.57	99.2
210102	Нэмэгдэл	102,106,400.00	102,106,400.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,161,800.00	5,852,072.47	309,727.53	94.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6,161,800.00	5,852,072.47	309,727.53	94.9
2104	Хангамж, бараа материалын зардал	19,827,200.00	19,827,200.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	560,000.00	560,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	17,372,200.00	17,372,200.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	595,000.00	595,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,070,000.00	15,070,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,000.00	600,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	5,470,000.00	5,470,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	17,194,000.00	17,194,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	17,194,000.00	17,194,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,442,100.00	7,442,100.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,660,000.00	3,660,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,100.00	277,100.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,320,000.00	38,320,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	320,000.00	320,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,000,000.00	38,000,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	403,249,200.00	401,388,992.90	1,860,207.10	99.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	403,249,200.00	401,388,992.90	1,860,207.10	99.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	403,249,200.00	401,388,992.90	1,860,207.10	99.5
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	20	2	90.9
620002	Гүйцэтгэх ажилтан	18	16	2	88.8
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22	20	2	90.9
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	22	20	2	90.9

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.20	Аудитын нэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: СГА-2020/242/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууныг норм лимитээр тооцож олгоогүйгээс 3,111.1 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан	3,111.1	Албан шаардлага	Нягтлан бодогч	Л.Баярцэцэг
2	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22,796.7 мянган төгрөгийн хөрөнгө байна.	22,796.7	Зөвлөмж	Нягтлан бодогч	Л.Баярцэцэг
	Нийт	25,907.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 28

№ 02/38

Улаанбаатар хот

СЯТ- 2020/042/СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан, Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууныг норм, лимитээр тооцож олгоогүй 3,111.1 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт "Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 -д гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууныг нормоос хэтрүүлэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож цаашид давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 20-ны дотор ирүүлэхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал ахмад Х.Батбаяр, ахлах нягтлан бодогч, ахмад Л.Баярцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
Д.ЦЭГМИДДОРЖ
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ч.МӨНХТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА МЭРГЭЖЛИЙН
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ АХМАД
Х.БАТБАЯР
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ, АХМАД
Л.БАЯРЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10\Bichie_Kheree\Alhan Shaardlaaa\2020\0228SAG9.Docx

001080105